


## Мөнгөний тойм

2012 оны 12 дугаар сар

### Инфляци

Хэрэглээний үнийн улсын индекс<sup>1</sup> 2012 оны 12 дугаар сарын эцэст өмнөх сараас 0.8 хувь, өмнөх оны мөн үеэс 14.0 хувь, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс өмнөх сараас 0.7 хувь, өмнөх оны мөн үеэс 14.2 хувиар тус тус өслөө. Суурь инфляци<sup>2</sup> сарын 0.3 хувь, жилийн 11.1 хувь байв.



Хүнсний болон тээврийн бүлгийн бараа бүтээгдэхүүний өсөлт сарын инфляцийн дийлэнх хувийг бүрдүүлжээ. Сарын инфляцийг 100 хувь гэж авч үзвэл 70 орчим хувийг хүнсний барааны өсөлт, 30 орчим хувийг тээврийн бүлгийн бараа үйлчилгээний өсөлт бүрдүүлсэн байна. Махны үнэ 1.5 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 2.6 хувь, хүнсний ногооны үнэ 7.3 хувиар өссөн бол тээврийн бүлгээс бүх төрлийн бензинийн үнэ 3.0 орчим хувиар мөн автомашины үнэ 2.3 хувиар нэмэгдсэн байна.

Тухайн сард нийт хэрэглээний сагсыг бүрдүүлж буй 329 бараа үйлчилгээнээс 65 бараа үйлчилгээний үнэ нь өсч, 10 бараа үйлчилгээнийх буурсан байна.

2012 оны 12 дугаар сарын байдлаар жилийн инфляцийн 41 хувийг хүнсний бараа, бүтээгдэхүүний инфляци, 59 хувийг хүнснээс бусад бараа үйлчилгээний инфляци бүрдүүлсэн байна. Үүнийг өмнөх онтой харьцуулахад нийт инфляцид хүнсний бараа, бүтээгдэхүүний инфляцийн үзүүлэх нөлөө 17 нэгж хувиар нэмэгджээ.

Хэрэглээний үнийн индексийн жилийн өөрчлөлтийг бүлгээр нь авч үзвэл хүнсний барааны үнэ 19.9 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийнх 54.6 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 13.0 хувь, боловсролын үйлчилгээнийх 16.1 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийнх 8.7 хувиар тус тус өсчээ.

### Мөнгөний нийлүүлэлт


Мөнгөний нийлүүлэлт<sup>3</sup> өмнөх сараас 8.3 хувь, өмнөх оны мөн үеэс 18.8 хувиар өсч 7617.3 тэрбум төгрөгт хүрэв. Төгрөгийн харилцах, хадгаламжийн сарын өсөлт нь M2 мөнгөний сарын өсөлтийн дийлэнх буюу 85 гаруй хувийг бүрдүүлсэн байна. 2012 оны 8 дугаар сараас хойш тасралтгүй буурч байсан мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт өмнөх сарынхаас 3.7 нэгж хувиар нэмэгджээ.

<sup>1</sup> Үндэсний Статистикийн Хорооны мэдээ.


<sup>2</sup> Мах, сүү, хүнсний ногоог хэрэглээний сагснаас хасч тооцов.

<sup>3</sup> M2-мөнгөний нийлүүлэлт нь Бараг мөнгө, M1 мөнгөний нийлбэр.

Тайлант сард банкнаас гадуурх мөнгөний жилийн өсөлтийн хурд өмнөх сарынхаас 14.0 нэгж хувь, төгрөгийн хадгаламжийнх 7.1 нэгж хувь, гадаад валютын хадгаламжийнх 4.2 нэгж хувь, төгрөгийн харилцахынх 1.5 нэгж хувиар тус тус өсч, харин гадаад валютын харилцахынх 7.8 нэгж хувиар буурсан байна.



Мөнгөний үзүүлэлтүүдийн 2012 оны 12 дугаар сарын өөрчлөлтийг авч үзвэл төгрөгийн хадгаламж 323.4 тэрбум төгрөг, төгрөгийн харилцах 175.6 тэрбум төгрөг, банкнаас гадуурх мөнгө 102.7 тэрбум төгрөг, гадаад валютын хадгаламж 2.4 тэрбум төгрөгөөр тус тус өсч, харин гадаад валютын харилцах 19.9 тэрбум төгрөгөөр буурчээ.




Нийт мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн 47.8 хувийг төгрөгийн хадгаламж,

37.9 хувийг гадаад валютын хадгаламж, 7.2 хувийг банкнаас гадуурх мөнгө, 6.5 хувийг гадаад валютын харилцах, 0.7 хувийг төгрөгийн харилцах тус тус бүрдүүлжээ.

### Хадгаламж

Нийт хадгаламж өмнөх сарынхаас 7.1 хувь буюу 325.7 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 26.5 хувь буюу 1032.4 тэрбум төгрөгөөр өсч 4922.8 тэрбум төгрөгт хүрэв.



Аж ахуйн нэгж, байгууллагуудын төгрөгийн хадгаламж өмнөх сараас 46.2 хувь буюу 119.7 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 16.3 хувь буюу 53.0 тэрбум төгрөгөөр өсч 378.8 тэрбум төгрөг болсон бол иргэдийн төгрөгийн хадгаламж өмнөх сараас 7.0 хувь буюу 203.6 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 20.2 хувь буюу 522.6 тэрбум төгрөгөөр өсч 3109.2 тэрбум төгрөгт хүрчээ. Гадаад валютын хадгаламж өмнөх сарынхаас 0.2 хувь буюу 2.4 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 46.7 хувь буюу 456.8 тэрбум төгрөгөөр өсч 1434.7 тэрбум төгрөг болжээ.


Нийт хадгаламжийн 70.9 хувь нь төгрөгийн, 29.1 хувь нь валютын хадгаламж байсан бөгөөд төгрөгийн хадгаламжийн нийт

хадгаламжинд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 4.0 нэгж хувиар буурчээ.

### Гадаад, дотоод цэвэр актив

Монгол Улсын Засгийн газар 2012 оны 12 дугаар сард олон улсын зах зээл дээр 1.5 тэрбум ам.долларын бондыг арилжаалсантай холбоотойгоор Монгол банк дахь ЗГ-ын хадгаламж 2.1 их наяд төгрөгөөр нэмэгдэж, улмаар ЗГ-ын цэвэр зээл 2.1 их наяд төгрөгөөр буурчээ. Энэ нь гадаад цэвэр активын өсөлтөд мөн нөлөөлсөн байна. Гадаад цэвэр актив өмнөх сараас 83.7 хувь буюу 2006.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 4404.7 тэрбум төгрөгт, гадаад албан нөөц өмнөх сараас 63.0 хувь буюу 1403.6 сая ам.доллараар нэмэгдэж 3630.0 сая ам.доллар болжээ.

Дотоод цэвэр актив өмнө дурдсан ЗГ-ын цэвэр зээлийн бууралтаас шалтгаалан өмнөх сараас 30.7 хувь буюу 1422.3 тэрбум төгрөгөөр буурч 3212.7 тэрбум төгрөг болов.



Нийт мөнгөний 57.8 хувь нь гадаад цэвэр активт, 42.2 хувь нь дотоод цэвэр активт байршиж байна.

### Нөөц мөнгө


Нөөц мөнгө өмнөх сараас 2.6 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 30.5 хувиар нэмэгдэж 2166.2 тэрбум төгрөгт хүрэв. Тайлант сард банкнаас гадуурх мөнгө 20.5 хувь буюу 102.7 тэрбум төгрөг, банкуудын касс 1.7 хувь буюу 3.7 тэрбум төгрөгөөр өссөн бол Төв банк дахь харилцах, хадгаламж 11.0 хувь буюу 164.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Банкуудын Төв банк дахь харилцах, хадгаламжийн нөөц мөнгөнд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 4.7 нэгж хувиар нэмэгдэж 61.9 хувь болсон бол банкуудын кассын эзлэх хувь 1.4 нэгж хувиар буурч 10.3 хувь, банкнаас гадуурх мөнгөнийх 3.3 нэгж хувиар буурч 27.9 хувь болсон байна.


### Зээл

Хадгаламжийн байгууллагуудаас<sup>4</sup> олгосон зээл өмнөх сарынхаас 1.8 хувь буюу 122.8 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 23.9 хувь буюу 1349.3 тэрбум төгрөгөөр өсч 6990.5 тэрбум төгрөгт хүрчээ. Хадгаламжийн байгууллагуудаас хувийн хэвшилд олгосон нийт зээл өмнөх сараас 3.0 хувь буюу 112.1 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 24.5 хувь буюу 755.4 тэрбум төгрөгөөр өсч 3837.4 тэрбум төгрөгт, иргэдэд олгосон зээл өмнөх сараас 0.5 хувь буюу 16.7 тэрбум төгрөг, өнгөрсөн оны мөн үеэс 26.4 хувь буюу 646.9 тэрбум төгрөгөөр өсч 3099.6 тэрбум төгрөгт хүрсэн байна.

<sup>4</sup> Хадгаламжийн байгууллагад банкуудаас гадна мөнгөний нийлүүлэлтийн тооцоонд ордог харилцах, хадгаламж хэлбэрээр бусдаас хөрөнгө татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллага (Хадгаламж, зээлийн хоршоо) хамрагдана.



Нийт зээлийг өмчлөгчөөр нь авч үзвэл 54.9 хувь нь хувийн хэвшил, 44.3 хувь нь иргэд, 0.6 хувь нь улсын байгууллага, 0.2 хувь нь бусад байгууллагад олгосон зээл байна.




Нийт зээлийн үлдэгдлийн 94.2 хувийг хэвийн зээл, 1.6 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 4.2 хувийг чанаргүй зээл тус тус эзлэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1.6 нэгж хувиар буурчээ. Банк бус санхүүгийн байгууллагуудын<sup>5</sup> нийт зээлийн өрийн үлдэгдэл нь 2012 оны 3 дугаар улирлын байдлаар 154.4 тэрбум төгрөг байсан бөгөөд нийт санхүүгийн байгууллагуудаас эдийн засагт оруулсан зээлийн үлдэгдэл 7145.0 тэрбум төгрөгт хүрчээ.

<sup>5</sup> Санхүүгийн байгууллагад банк болон бусдаас хөрөнгө татан төвлөрүүлдэг санхүүгийн байгууллагаас гадна банк бус санхүүгийн байгууллага, Хөгжлийн банк орно.

## Хүү


Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү 2012 оны 12 дугаар сард өнгөрсөн оны мөн үеэс 1.2 нэгж хувиар өсч жилийн 15.47 хувь болов. Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 2.7 нэгж хувиар өсч жилийн 18.2 хувь болсон бол гадаад валютынх өнгөрсөн оны мөн үеэс 1.4 нэгж хувиар өсч жилийн 13.5 хувь болжээ.



Харилцахын жигнэсэн дундаж хүү өөрчлөлт багатай байгаа бөгөөд төгрөгийн харилцахын жигнэсэн дундаж хүү жилийн 2.7 хувь, валютынх жилийн 1.3 хувьтай байна. Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 1.2 нэгж хувиар өсч жилийн 11.7 хувь болсон бол валютын жигнэсэн дундаж хүү өнгөрсөн оны мөн үеэс 1.5 нэгж хувиар өсч жилийн 6.1 хувь болов.

## Мөнгөний зах

2012 оны 12 дугаар сард банк хоорондын захын арилжаагаар нийт 272.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгджээ. Эдгээр арилжааны жигнэсэн дундаж хүү жилийн 13.97 хувь байна.



2012 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс 2012 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хугацаанд банкууд дунджаар төгрөгийн заавал байлгах нөөцөд 567.2 тэрбум төгрөг, валютын заавал байлгах нөөцөд 376.9 тэрбум төгрөг байлгах шаардлагыг хангаж ажиллав. Банкууд төгрөгийн заавал байлгах нөөцөд 643.3 тэрбум төгрөг, валютын нөөцөд 694.1 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн байна.

### Валютын ханш

Төгрөгийн ам. доллартай харьцах ханш 2012 оны 12 дугаар сарын эцэст 1392.10 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5 төгрөгөөр чангарсан байна. Тайлант сард төгрөгийн ам. доллартай харьцах дундаж ханш 1396.11 төгрөг байв.

